



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/465

Булган сум

┌ Ургацын комисс шинэчлэн ┐
байгуулж, ургацын штаб ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 47 дугаар “Аян өрнүүлэх тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг эрчимжүүлэх, хаврын тариалалт, ургац хураалт, хадлан бэлтгэлийн ажлыг шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах ургацын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Орлогч дарга: Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Онцгой байдлын газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Цагдаагийн газрын дарга

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

“Булган АЗЗА” ТӨХК-ийн захирал

Сумын Засаг дарга нар

Тариаланчдын холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга: Хүнс, хөдөө аж ахуйн газрын агрономич

2. Ургац хураалтын ажлыг технологит хугацаанд хураан авах, тоо мэдээг нэгтгэх, үүссэн асуудалтай холбогдуулан ургацын комиссыг хуралдуулж, шийдвэрийг биелүүлэх ургацын штабыг жил бүрийн 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ургац хураалт дуустал хугацаанд ажиллуулж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Ургацын комисс (О.Ундрах)-т үүрэг болгосугай.

6325010635

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/546 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

